



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 5 сарын 03 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, Баримт бичгийг нягтлан шалгах, дүгнэлт, санал боловсруулж Хорооны хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийг бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичиг хүлээн авсан тухай тэмдэглэл"-ийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвслээс нэр дэвшигчдийн баримт бичгийг хүлээн авахдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу намын улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдгийг дугаар зэргийг нягтлан шалгаж хүлээн авахыг нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах Ажлын хэсэг /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн A/22 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН